ШИНЭ SARS-COV-2 ХАЛДВАРЫН ЦАР ТАХЛЫН ГОЛОМТОНД АЖИЛЛАСАН ЭМЧ МЭРГЭЖИЛТҮҮДИЙН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Лувсанняндаг Б[1,2], Мөнх Э[1,2], Оюунсүрэн Д[1], Хишигсүрэн З[1], Наранзул Д[3], Одмаа Э[3], Тунсаг М[3], Оюунгэрэл Р[3]

[1]АШУҮИС, АУС, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Тэнхим
[2]СЭМҮТ
[3]ХӨСҮТ
luvsaabazar88@gmail.com

Түлхүүр үг:
КОВИД-19, эрүүл мэндийн ажилтнууд, сэтгэлзүйн тусламж, сэтгэцийн шинжүүд

Товч утга: Үндэслэл: 2019 оны төгсгөл үеэс эхлэн дэлхий нийт шинэ SARS-CoV-2 халдварын цар тахалтай нүүр тулгараад байна. Энэ дэгдэлтийн үеэр эрүүл мэндийн ажилтнууд болон олон нийтийн дунд гэмтлийн дараах стрессийн эмгэг, сэтгэлийн түгшилт, сэтгэл гутрал зэрэг сэтгэцийн шинжүүд бүртгэгдсээр байгаа билээ. Энэхүү судалгааны зорилго нь шинэ SARS-CoV-2 халдварын цар тахлын голомтонд ажиллаж буй эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн дунд тохиолдож байгаа сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудлуудыг илрүүлэхэд чиглэсэн болно.

Материал, аргазүй: Энэхүү судалгааг тойм судалгааны агшингийн загвараар хийв. Бид тусгайлан боловсруулсан асуумжийг ашиглан нийт 369 эмч, мэргэжилтнийг хамруулан мэдээллийг цуглуулсан болно.

Үр дүн: Судалгаанд 22-63 насны хүмүүс оролцсоноос 87 нь эрэгтэй, 282 нь эмэгтэй хүйсийнх, дундаж нас 37.9 ± 8.7 байв. Насны бүлгээр нь авч үзвэл 25-54 насныхан илүү олон байна. Нийт судалгаанд хамрагдагсдын 15% (n=56) нь халдвараас айж байгаа гэж үнэлсэн бөгөөд 19% (n=71) нь маш их айдастай гэж хариулжээ. Судалгаанд хамрагдагсдын 26.8% нь сэтгэлийн түгшүүртэй, 38.7% нь сэтгэл гутралд орсон байна. Сэтгэлийн түгшүүр, сэтгэлийн гутралтай оролцогсодын ихэнхи нь дундаас хүнд зэргийн түвшинд сэтгэлзүйн нөлөөлөл илэрч байгаа гэж үнэлжээ. Цаашилбал нийт судалгаанд хамрагдагсдын 80.5% (n=297) нь эмнэлгүүдэд ажилчдад зориулсан стресс менежментийн өрөө шаардлагатай гэж, 64.8% (n=239) нь сэтгэлзүйн тусламж шаардлагатай гэж мэдээлсэн байна.

Дүгнэлт: SARS-COV-2 халдварын улмаас өвчтөнүүдтэй ажиллаж, тусгаарлагдсан өвчтөнүүдийн дунд эрүүл мэндийн ажилтнуудын 26.8% нь сэтгэлийн түгшүүртэй, 38.7% нь дунд зэрэгээс хүнд байдлаар сэтгэлээр унасан байлаа. Судалгаанд хамрагдагсдын 64.8%-80.5% нь эмнэлгүүдэд ажилчдад зориулсан сэтгэлзүйчийн тусламжтай стресс тайлах шаардлагатай байгаа хэмээн үзжээ.

Үндэслэл: Халдварт өвчний цар тахал хэлбэрийн дэгдэлт нь нэгэн зэрэг олон хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулж болзошгүй аюултай, хувь хүний үнэт зүйлсийг сүйрүүлэн хүнд гарз хохирол учруулах нөлөөтэй, цаг бусын, гэнэтийн сүйрүүлэх хүчтэй стрессийн нэг төрөл юм[1]. 2019 оны сүүлчээр БНХАУ-д хүн амын дунд эндэгдэл өндөртэй уушгины үрэвсэл тархаж эхэлсэн тухай ДЭМБ-д мэдээлсэн коронавирусын шалтгаантай байсан ба ДЭМБ шинэ коронавирүсээр сэдээгдсэн өвчнийг COVID-19 хэмээн нэрлэж, 2020 оны 3 сарын 11-д цар тахлын хэмжээнд хүрснийг зарласан билээ. 2020 оны 10 сарын 14-ны байдлаар, дэлхийн 216 улс орон, дэвсгэр нутгийн 37 сая гаруй хүн уг халдвараар өвчилж, 10792029 гаруй хүн нас бараад байна [2,3]. COVID-19-ийн халдвартай холбоотой хийгдсэн эрт үеийн судалгаануудын дүгнэлтэнд уг халдвараар өвчлөгсөд, эмчлүүлэгч, тусгаарлалтанд байгаа хүмүүс , эмч эмнэлгийн ажилтны сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлон үнэлэх, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тогтоох шаардлагатай болохыг санал болгосон байдаг[4]. БНХАУ-ын 194 хотод хийсэн түүвэр судалгаагаар, COVID-19-ийн халдварын цар тахал нь хүмүүсийн сэтгэлзүйд дундаас хүнд зэргийн түвшний стрессийн нөлөө үзүүлсэн бөгөөд сэтгэл түгшилт, сэтгэл гутрал дундаас хүнд түвшинд илэрсэн байв[5].


COVID-19-ийн халдварын цар тахалын голомтонд гар бие оролцон ажиллаж буй халдвартын, дотрын болон эрчимт эмчилгээний тасгийн эмч, эмнэлгийн ажилчдын дунд хийгдсэн 14 судалгааны ажлыг нэгтгэн үнэлсэн үр дүнгээс харахад, эмч эмнэлгийн ажилчдын стрессийн туршлагаас хамааран сэтгэл түгшилт, сэтгэл гутрал илүү илэрч байсан бөгөөд сэтгэлзүйн хямралын хүндийн зэрэг нь нас, хүйс, ажил мэргэжил, мэргэшил, гүйцэтгэсэн үйл ажиллагааны төрөл, COVID-19-ийн халдвартай өвчинтэй хир ойр байсантай хамааралтай байсан байна[6]. Манай орны хувьд 2020 оны 3-р сараас өнөөг хүртэл шинэ коронавирүст халдварын улмаас эмчлүүлэгчид, тусгаарлагдагсадтай ажиллаж байсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлын нөхцөлд ажил үүргээ гүйцэтгэх явцад тэдний бие сэтгэцийн эрүүл мэндийн байдалд эрсдэл үүсгэж болзошгүй байгаа нь энэхүү судалгааны ажлын үндэслэл болсон юм.

Зорилго: Шинэ коронавирүст халдвар (*SARS-COV-2*)-ын улмаас эмчлүүлэгчсэд, тусгаарлалтанд байгаа хүмүүстэй ажиллаж байгаа болон ажиллаж байсан эмч мэргэжилтнүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудлыг судлан тодорхойлох

Судалгааны ажлын ёс зүй: Судалгааны ёс зүйн асуудлыг Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл авсан (2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тогтоол, дугаар № 172). Судалгаанд хамрагдагсдаас таниулсан зөвшөөрлийн хуудсаар дамжуулан зөвшөөрөл авч, гарын үсгээр баталгаажуулсан болно.

Судалгааны материал, арга зүй: Судалгааг тойм судалгааны агшингийн загвараар зохион байгуулж, шинэ SARS-COV-2 халдвартай өвчтөнийг эмчлэх, тээвэрлэх, сувилах, асрах үйл ажиллагаанд оролцсон, тусгаарлах байранд тусламж үйлчилгээ үзүүлж буй нийт 369 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулав. ЭМЯ-ны захиалгаар БСШУСЯ-ны ШУТС-ийн санхүүжилттэй АШУҮИС, ХӨСҮТ хамтран гүйцэтгэсэн "Монгол улсад бүртгэгдсэн шинэ коронавирүст халдвар (SARS-COV-2)-ын эмнэлзүйн судалгаа"-ны төсөлт ажлын хүрээнд бид цар тахлын голомтонд эмчлүүлэгч, тусгаарлалтанд байсан хүмүүстэй ажилласан эмч эмнэлгийн мэргэжилтнүүдээс тусгайлан боловсруулсан асуумж судалгааны картыг цаасан болон цахим хэлбэрээр ашиглан зохих мэдээллийг цуглуулсан.

Үр дүн: Судалгаанд хамрагдагсад нь 22-63 насны, эрэгтэй 87, эмэгтэй 282 байсан ба дундаж нас 37.9± 8.7 байлаа. Насны бүлгээр авч үзвэл 25-54 насныхан илүү байв. Судалгаанд оролцогчид нь улсад 1-40 жил ажилласан ба үүнээс 44 хүн 1 жил хүртэлх хугацаагаар ажиллаж байгаа, нийт тохиолдлын ажилласан жилийн дундаж нь 10. 78± 87 жил байсан болно. Судалгаанд хамрагдагсдаас ажил үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа халдвар авахаас айх айдас байсан эсэхийг Ликертийн 0-5 оноог ашиглан өөрөөр нь үнэлүүлэв. (Зураг 1)



Зураг 1. Судалгаанд оролцсон эмч, эмнэлгийн ажилчдын халдвар авахаас айх айдсын түвшин (өөрийн үнэлгээгээр)

Зураг 1-д харуулснаар, судалгаанд оролцсон нийт эмч, эмнэлгийн ажилчдын 15% буюу 56 хүн айдас байгаагүй гэсэн бол, 85% нь халдвар авах айдастай, үүнээс 19% (n=71) нь маш их айдастай байсан гэж хариулсан байх бөгөөд ялангуяа тусгаарлалтанд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажиллагсад илүү айдастай байсан байна. Нарийвчлан авч үзвэл батлагдсан тохиолдлыг эмчлэгч эмч нарын 82.8%, сувилагч нарын 83%, туслах сувилагч нарын 86%, лабораторийн ажилчдын 58%, тусгаарлалтанд ажиллагсдын 85%, удирдах албанд ажиллагсад 100%, бусад ажиллагсдын 85% нь халдвар авах айдастай байсан хэдий ч статистик ач холбогдол бүхий ялгаагүй байлаа (x^2=27.26, p=0.07).

Хүснэгт 1. Эмч эмнэлгийн ажилчдын сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн үнэлгээ

Сэтгэл гутрал			Сэтгэл түгшилт		
Сэтгэл гутралын түвшин	N	%	Сэтгэл түгшилтийн түвшин	N	%
Сэтгэл гутралгүй	188	50.9	Сэтгэл түгшилтгүй	245	66.4
Бага зэрэг	143	38.7	Бага зэрэг	99	26.8
Дунд зэрэг	29	7.8	Дунд зэрэг	21	5.7
Хүндэвтэр	6	1.63	Хүндэвтэр	4	0.8
Хүнд	3	0.8			
Бүгд	369	100	Бүгд	369	100

Хүснэгт 1-ээс үзвэл судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын 50.9% нь сэтгэл гутралгүй, 66.4% нь сэтгэл түгшилтгүй болох нь сорилын үр дүнгээр тогтоогдсон бол сэтгэл гутралтай (38.7%), сэтгэл түгшилттэй (26.8%) эмч, эмнэлгийн ажилчдын олонхи нь дунд зэргийн түвшний өөрчлөлттэй байлаа.

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын сэтгэлзүйн хэвшинж, сэтгэл гутрал, сэтгэл түгших шинжийн хамаарал

	Сэтгэлзүйн хэвшинж		Сэтгэл гутрал		Сэтгэл түгшилт	
	N	%	X^2	p	X^2	p
Сангвиник	113	40.6	2.16	0.7	0.79	0.8
Флегматик	67	18.1	4.05	0.3	1.41	0.7
Меланхолик	55	14.9	1.13	0.8	1.58	0.6
Холерик	134	36.3	3.21	0.5	0.53	0.9

Хүснэгт 2-д харуулснаар, судалгаанд оролцсон нийт эмч эмнэлгийн ажилтны хувь хүний сэтгэлзүйн хэвшинжийг сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн түвшинтэй харьцуулан үзвэл статистик ач холбогдолгүй байсан болно. Судалгаанд хамрагдагсдыг ажил үүргээ гүйцэтгэж байх хугацаанд өөрт нь сэтгэл зүйн тусламж шаардлагатай байсан эсэх талаарх асуумжинд n=139 (38%) нь шаардлагатай, n=19 (5%) нь нэн шаардлагатай хэмээн хариулжээ. Түүнчлэн судалгаанд хамрагдагсдын 80.5% (n=297) нь эмнэлгүүдэд ажилчдын стресс тайлах өрөө шаардлагатай гэсэн бол 64.8% (n=239) нь сэтгэлзүйчийн хэрэгцээ байдаг хэмээн хариулсан байв.

Хэлцэмж: COVID-19 бол бетакоронавирус[7] бөгөөд *SARSCoV-1*[8] гэх мэт титэм вирусын бүлгийн бусад дэгдэлт, тухайлбал *SARS* тахлын үеэр бүртгэгдсэн сэтгэцийн шинжүүд болох сэтгэлзүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг, сэтгэлийн түгшүүр, сэтгэл гутрал зэрэг нь шинэ *SARSCoV-2* вируст халдварын энэхүү цар тахлын үед олон нийтийн дунд төдийгүй эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд ч бүртгэгдсээр байна[9,10.] Шинэ коронавируст халдварын тусгаарлалтанд ажиллаж байсан эмч, сувилагч нарын дунд сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, айдас өндөр түвшинд тодорхойлогдож байсныг Их Британи, Ливаны болон Хятадын судлаачид судлан тогтоожээ[11,12,13].

Бидний судалгааны дүнгээс харахад манай судалгаанд хамрагдагсдын 26.8%-д нь сэтгэл түгшилт, 38.7%-д нь сэтгэл гутралын байдал багаас хүнд зэргийн түвшинд тодорхойлогдсон бөгөөд 64.8%-80.5% нь сэтгэлзүйчийн тусламжийн хэрэгцээ байдаг, эмнэлгүүдэд ажилчдын стресс тайлах өрөө шаардлагатай хэмээн хариулсанаас үзвэл эмч, эмнэлгийн ажилчдын дунд стресс их байдаг гэж үнэлж болохоор байлаа. Түүнчилэн ийнхүү хариулж байгаа нь эмч эмнэлгийн мэргэжилтний дунд ажлын байрны стресс их байдагтай холбоотой бус, харин хүн амын дунд стресс их байдаг (гэр бүл, ахуй амьдрал, эрүүл мэнд, эдийн засгийн, улс төрийн гэх мэт шалтгаантай) гэдгийг илэрхийлэх үзүүлэлт байж болох юм.

Дүгнэлт: Шинэ коронавирүст халдвар (SARS-COV-2)-ын улмаас эмчлүүлэгчсэд, тусгаарлагдагсадтай ажиллаж байгаа болон ажиллаж байсан эмч мэргэжилтнүүдийн 26.8%-д нь сэтгэл түгшилт, 38.7%-д нь сэтгэл гутралын байдал дундаас хүнд зэргийн түвшинд тодорхойлогдсон бөгөөд 64.8%-80.5% нь сэтгэлзүйчийн хэрэгцээ байдаг, эмнэлгүүдэд ажилчдын стресс тайлах өрөө шаардлагатай гэж үзжээ.

Талархал: Энэхүү судалгааг зохион байгуулахад дэмжин ажилласан ЭМЯ, УОК, ХӨСҮТ-ийн удирдлага, АШУҮИС-ийн АУС-ийн Халдварт өвчин судлалын тэнхмийн багш судлаач нар, судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, хамтран ажилласан багийнхаа хамт олонд гүн талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Бямбасүрэн С. "Гамшгийн үеийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал. Улаанбаатар хот. 2002 он. х. 3*
2. *Нямдаваа П. Цартахал. Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл.2020 №4 (93) х. 1*
3. *https://covid19.who.int/ accessed on 14 October 2020*
4. *Shalev D, Shapiro PA. Epidemic psychiatry: The opportunities and challenges of COVID-19. Gen Hosp Psychiatry. 2020;64:68□71. DOI:10.1016/j.genhosppsych.2020.03.009*
5. *Wang C, Pan R, Wan X, et al. Immediate Psychological Responses and Associated Factors during the Initial Stage of the 2019 Coronavirus Disease (COVID-19) Epidemic among the General Population in China. Int J Environ Res Public Health. 2020;17(5):1729. Published 2020 Mar 6. DOI:10.3390/ijerph17051729*
6. *Bohlken J, Schμmig F, Lemke MR, Pumberger M, Riedel-Heller SG. COVID-19 Pandemic: Stress Experience of Healthcare Workers - A Short Current Review. Psychiatr Prax. 2020 May;47(4):190-197. DOI: 10.1055/a-1159-5551. Epub 2020 Apr 27.*
7. *Lu, R., et al. Genomic characterization and epidemiology of 2019 novel coronavirus: implications for virus origins and receptor binding. The Lancet (London, England), 2020a; 395: 565–574.*
8. *Cui, J., Li, F., Shi, Z.-L. Origin and evolution of pathogenic coronaviruses. Nat. Rev. Microbiol, 2019; 1: 181–192.*
9. *Cheng, S.K.-W., Tsang, J.S.-K., Ku, K.-H., Wong, C.-W., Ng, Y.-K. Psychiatric complications in patients with severe acute respiratory syndrome (SARS) during the acute treatment phase: a series of 10 cases. Br. J. Psychiatry, 2004a; 184: 359–360.*
10. *Lancee, W.J., Maunder, R.G., Goldbloom, D.S. Prevalence of psychiatric disorders among Toronto hospital workers one to two years after the SARS outbreak. Psychiatr. Serv, 2008; 59: 91–95.*

11. Nickell, L. A. Psychosocial effects of SARS on hospital staff: Survey of a large tertiary care institution. Canadian Medical Association Journal, 2004;170(5): 793–798
12. Khalid, I., Khalid, T. J., Qabajah, M. R., Barnard, A. G., & Qushmaq, I. A. Healthcare worker's emotions, perceived stressors, and coping strategies during a MERS-CoV outbreak. Clinical Medicine & Research, 2016; 14(1): 7–14
13. Duan, L., & Zhu, G. Psychological interventions for people affected by the COVID-19 epidemic. The Lancet Psychiatry, 2020;7(4): 300–302.

MENTAL HEALTH ASSESSMENT OF HEALTH CARE PROFESSIONALS ARE WORKED IN SARS-COV-2 OUTBREAK FIELD

Luvsannyandag B[1,2], Munkh E[1,2], Oyunsuren D[1], Khishigsuren Z[1], Naranzul D[3], Odmaa E[3], Tunsag M[3], Oyungerel R[3]

[1]Department of Mental Health, SoM, MNUMS
[2]National Center for Mental Health
[3]National Center of Communicable Diseases
luvsaabazar88@gmail.com

Introduction: Since the end of 2019, the world was facing the COVID-19 pandemic with a novel coronavirus, *SARS-CoV-2*. Psychiatric symptoms including posttraumatic stress disorder, anxiety, and depression both in health care workers and the public during this outbreak. The goal of this study was to identify some mental health problems among health professionals, are working with cases, and isolated patients due to *SARS-CoV-2* outbreaks.

Methods: A descriptive and cross-sectional research design was conducted. We used a semi-structured questionnaire and involved a total of 369 health care professionals.

Results: The respondents were 22-63 years old, 87 males and 282 females, with an average age of 37.9±8.7. By age group, there are more subjects aged 25-54. Of the total respondents, 15% (n=56) rated they were afraid of infection, and 19% (n=71) rated they were very scared. 26.8% of the total respondents have anxiety, and 38.7% have depressed. The majority of the respondents with anxiety or depression rated the psychological impact as moderate-to-severe. Furthermore, 80.5% (n = 297) of the total respondents reported that hospitals need stress management rooms for employees, and 64.8% (n = 239) reported that there is necessary psychological care.

Conclusion: Among health care workers, worked with cases and isolated patients due to *SARS-COV-2* infections, 26.8% have anxiety, and 38.7% are depressed as moderate-to-severe. Furthermore, 64.8% -80.5% of the total respondents reported that hospitals need stress management rooms for employees, and necessary psychological care.

Keywords: COVID-19, health staff, psychological care, psychiatric symptoms